



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар A/56

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын  
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Далт ХХК-ны "Далт" дэн буудлын 13/200, Н.О.Т трейд ХХК-ны "Нарлаг" зочид буудлын 15/039, Алкес ХХК-ны "Жули" дэн буудлын 13/239, ЦПО ХХК-ны "Од" дэн буудлын 16/029 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэд нь гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг

хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Огонсувд/-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 06 сарын 29 өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1117139265  
УГА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.06.29

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ичмон ХХК	6144608	Ичмон	Б3Д-ийн 3-р хороо Токиогийн гудамж-24/3

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 06 сарын 19  
өдрийн АЛБС дугаар тушаалтын  
хоёрдугаар хавсралт

1117139265  
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.06.29

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Улсын бүртгэлийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Далт ХХК	2567512	Далт	БГД-ийн 19-р хороо ААӨЧ-51/2
2	АЛКЕС ХХК	2569809	Жүли	БЗД-ийн 6-р хороо Олзвойн гудамж АОС-5
3	Н.О.Т трейд ХХК	2733129	Нарлаг	СБД-ийн 8-р хороо Бага тойруу-33/2
4	ЦПО ХХК	5042771	Од	БЗД-ийн 7-р хороо Их тойруу-36

--ooOoo--